



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**Аймгийн сонгуулийн хороо нь СЕХ-ноос гаргасан
заавар, аргачлалын дагуу зардлыг хуваарилж,
зарцуулсан байна.**

2021 оны 07 дугаар сар



**Аудитын сэдэв: МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ ЗОХИОН
БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ**

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгийн тайлбар.....3
Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....4-5
Дарга, тэргүүлэх аудиторын үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Ган-Өлзий	Бүлэг 1. АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРОО СЕХ-ООС БАТАЛСАН ТӨСВИЙГ ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ХУВААРИЛАН ЗАРЦУУЛСАН БАЙНА.
Аудитын менежер У.Оюунтүлхүүр	1.1 Сонгуулийн ерөнхий хороо нь аймгийн сонгуулийн хороонд 419.5 сая төгрөгийн санхүүжилт хуваарилсан байна.....6
Аудитор Б.Ариунбаатар	1.2 Аймгийн сонгуулийн хороо нь сонгуулийн ерөнхий хорооноос өгсөн заавар, аргачлалын дагуу зардлыг хуваарилсан байна.....6-7
Аудитор Д.Дэмбэрэлсүрэн	1.3 Аймгийн сонгуулийн хороо нь батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж 8.0 сая төгрөгийг СЕХ-ны дансанд буцаан төвлөрүүлжээ.....7-9
2021 оны 07 дугаар сар	Бүлэг 2. АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРОО НЬ СУМДЫН СОНГУУЛИЙН ХОРООНЫ ЗАРДЛЫН ЗАРЦУУЛАЛТАД ХЯНАЛТЫГ БҮРЭН ТАВЬЖ ЧАДААГҮЙ БАЙНА.....9
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7052-2734, 7052-3020 дугаарын утас, 7052-2734 дугаарын факсаар харилцана уу	2.1 Аймгийн сонгуулийн хороо нь зардлын тайланг журмын дагуу гаргасан ч зарим сумдын сонгуулийн хорооны тайланд гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.....9-10
ХАЯГ: Сайншанд сум 3-р баг Орон нутгийн өмчийн 3-р байр	2.2 Аймгийн сонгуулийн хороо нь сумын сонгуулийн хорооны зардлын зарцуулалтад тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.....10-11
	Дүгнэлт.....12
	Холбогдох байгууллагын санал.....13

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АСХ	Аймгийн сонгуулийн хороо
МУ	Монгол Улс
НББ	Нягтлан бодох бүртгэл
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
ССХ	Сумын сонгуулийн хороо
СХХ	Сумын хэсгийн хороо

АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8¹, Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 4.5-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулан улсын төсвөөс санхүүжүүлсэн Дорноговь аймгийн сонгуулийн хорооны зардлын тайланд Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3²-т заасныг баримтлан аудит хийлээ.

АУДИТЫН ЗОРИЛТ:

Сонгууль зохион байгуулахтай холбогдсон Улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалтад аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн болно.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- Ерөнхийлөгчийн сонгуулийн батлагдсан төсвийг холбогдох хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилж, зарцуулсан эсэх;
- Сонгууль зохион байгуулах зардалд холбогдох хууль, журамд нийцүүлэн хяналт тавьж ажилласан эсэх;

АУДИТЫН ХАМАРСАН ХҮРЭЭ:

Аудитыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн 2021 оны сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулан СЕХ-ноос аймгийн сонгуулийн хороодод хуваарилан зарцуулсан төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын баримт материалуудыг хамруулан авч үзлээ.

АУДИТЫН АРГА ЗҮЙ:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 3000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-1 тулгуур зарчим, 6817-5 гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим, 6817-7 гүйцэтгэлийн аудитын стандарт, Гүйцэтгэлийн аудитын журмыг баримтлан шалгагдагч болон хамрагдагч байгууллагын сонгуулийн зардлын тайлан, холбогдох баримт материалыг шалгах, асуулга лавлагаа, тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх, харьцуулах, нэгтгэх, зэрэг аудитын горимыг хэрэгжүүлж, төлөвлөсөн арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт боловсруулав.

¹ Хуулийн 9.8-д Энэ хуулийн 9.1, 9.2, 9.3, 9.4, 9.5, 9.6, 9.7-д заасан зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд төрийн аудитын дээд байгууллага Төсвийн тухай хуульд заасны дагуу хяналт тавьж, аудит хийж, дүгнэлт гаргана.

² Хуулийн 6.3.Төрийн аудитын байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.3.1.шалгагдагч этгээдэд энэ хуулийн 11, 12 дугаар зүйлд заасны дагуу санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудит хийх;

АУДИТАД АШИГЛАСАН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:

Дараах хууль эрх зүйн актыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашигласан.
Үүнд:

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- СЕХ-ны 2021 оны А/17 дугаар тогтоолоор баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”

АУДИТЫН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА:

Аудитыг Дарга, тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер У.Оюунтүлхүүр хэрэгжүүлж, аудитор Б.Ариунбаатар, Д.Дэмбэрэлсүрэн нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

Аудитын 2021 оны 07 дугаар сарын 01-аас 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хооронд гүйцэтгэлээ.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Улсын Их Хурлаас Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр шинэчлэн баталж, 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөс даган мөрдөж эхэлсэн байна.

МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийг зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс АСХ-нд 419.5 сая төгрөгийг хуваарилсан байна.

Дорноговь аймгийн сонгуулийн хороо болон 14 сумын сонгуулийн хороо, 57 хэсгийн хороодод нийт 608 гишүүний бүрэлдэхүүнтэй ажилласан байна.

Аймгийн Сонгуулийн хороонд нийт 419.5 сая төгрөгийг СЕХ-ноос хуваарилснаас гүйцэтгэлээр нийт 411.5 сая төгрөг зарцуулж, 8.0 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

БҮЛЭГ 1. АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРОО СЕХ-ООС БАТАЛСАН ТӨСВИЙГ ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ХУВААРИЛАН ЗАРЦУУЛСАН БАЙНА.

1.1 Сонгуулийн ерөнхий хороо нь аймгийн сонгуулийн хороонд 419.5 сая төгрөгийн санхүүжилт хуваарилсан байна.

Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-т “Сонгууль зохион байгуулахтай холбогдсон дараах зардлыг сонгуулийн ерөнхий хорооны төсөвт тусгаж, улсын төсвөөс санхүүжүүлнэ”, Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 2.1-т “Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн төсвийг зохих эдийн засгийн ангиллын дагуу сонгогчийн тоо, сум дүүргийн болон хэсгийн хорооны тоо, тэдгээрт ажиллах ажилтнуудын тоог харгалзан аймаг нийслэлийн сонгуулийн хороо бүрээр хуваарилна”, гэж заасан байна.

СЕХ-ноос Дорноговь аймгийн нийт сонгогчид болон сумдын санал авах байр тэдгээрт ажиллах гишүүдийн тоог үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуулийн зардлыг төлөвлөн УИХ-аар батлуулж Дорноговь АСХ-нд 419.5 сая төгрөгийн санхүүжилт олгохоор хуваарилсан байна.

СЕХ-оос АСХ-д хуваарилсан төсөв /эдийн засгийн ангиллаар/

Хүснэгт №1

/төгрөгөөр/

№	Зардлын нэр	Төсөв	Эзлэх хувь
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	250.0	0.1
2	Бичиг хэргийн зардал	10,080.0	2.4
3	Шуудан, холбооны зардал	11,650.0	2.8
4	Унааны зардал	35,150.0	8.4
5	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	3,834.0	0.9
6	МТБ, даамлын сургалтын зардал	8,490.0	2.0
7	МТБ-ийн мэдээ дамжуулах холбоо, унааны зардал	2,000.0	0.5
8	Санал авах байр, Төрийн далбаа бэлтгэх зардал	18,240.0	4.3
9	Сурталчилгааны зардал	5,000.0	1.2
10	Саналын хуудас, төхөөрөмж авах, буцаан хүргэх зардал	16,394.0	3.9
11	Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх	2,565.0	0.6
12	Томилолтын зардал	4,702.0	1.1
13	Мэдээ дамжуулах унааны зардал	1,925.0	0.5
14	Сонгуулийн хорооны гишүүний урамшуулал, хоолны зардал	252,440.0	60.2
15	Мэдээллийн технологийн багийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	36,810.0	8.8
16	Болзошгүй зардал	10,000.0	2.4
НИЙТ ДҮН		419,530.0	100

СЕХ-оос АСХ-нд хуваарилсан төсвийн дийлэнх хэсгийг буюу 60.2 хувийг сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, хоолны зардал эзэлж байгаа бол хамгийн бага хувийг хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал 250.0 мянган төгрөг буюу 0.1 хувийг эзэлж байна.

1.2 Аймгийн сонгуулийн хороо нь сонгуулийн ерөнхий хорооноос өгсөн заавар, аргачлалын дагуу зардлыг хуваарилсан байна.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 захирамжаар батлагдсан "Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам" 2.3-т "Аймаг нийслэлийн сонгуулийн хороо нь СЕХ-оос өгсөн тайлбар аргачлалын дагуу сумын сонгуулийн хороонд зардлын төсвийг хуваарилна" гэж заасан байна.

СЕХ нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн АСХ-ны төсвийн санхүүжилтийг зарцуулах хуваарь, тайлбар аргачлалтайгаар тухай бүр олгосон байна.

АСХ нь уг хуваарь, тайлбар, аргачлалын дагуу 333.1 сая төгрөгийн санхүүжилтийг 14 ССХ-нд хуваарилж, тухай бүр чиглэл өгч ажиллажээ.

Сонгуулийн зардлын санхүүжилт

Хүснэгт №1

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	2021.04.22	2021.05.20	2021.05.28	2021.05.31	2021.06.07	2021.06.08	Нийт
Аймгийн Сонгуулийн хороо	18,324.0	26,096.0	10,000.0	31,977.0	0.0	0.0	86,397.0
Сумдын Сонгуулийн хороо	67,665.0	8,195.0	0.0	3,003.0	34,510.0	219,760.0	333,133.0
нийт дүн	85,989.0	34,291.0	10,000.0	34,980.0	34,510.0	219,760.0	419,530.0

Аймгийн СХ нь сонгуулийн хороодын санал авах байр, тэдгээрт ажиллах гишүүдийн тооны судалгааг үндэслэн сум тус бүрд бичиг хэргийн зардалд 120.0-160.0 мянган төгрөг, шуудан холбооны зардалд 150.0 мянган төгрөг, санал авах байр бэлтгэхэд 230.0 мянган төгрөг, төрийн далбаа бэлтгэх зардалд эхний хуваарилалтаар 25.0 мянган төгрөгөөр, 2 дахь хуваарилалтаар 15.0 мянган төгрөг нэмж хуваарилан төрийн далбаа бэлтгэх зардлыг 40.0 мянган төгрөгөөр тогтоосон байна. Мөн унааны зардлыг ССХ-нд 350.0 төгрөг, СХХ-нд 500.0 мянган төгрөгөөр тооцож санхүүжилтийг олгожээ. (төсвийн хуваарийг хавсралт №1-т харуулав)



Санхүүжилтийн 86.4 сая төгрөг буюу 21.0 хувийг АСХ, 333.1 сая төгрөг буюу 79.0 хувийг ССХ зарцуулахаар хуваарилсан байна.

1.3 Аймгийн сонгуулийн хороо нь батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж 8.0 сая төгрөгийг СЕХ-ны дансанд буцаан төвлөрүүлжээ.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 захирамжаар батлагдсан "Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих" журмын 3.8 "Сонгуулийн хороод нь хуваарилсан зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэхгүй бөгөөд шаардлагатай бол дээд шатны сонгуулийн байгууллагад албан ёсоор хүсэлт тавьж шийдвэрлүүлнэ" гэж заасан.

Аймгийн СХ-ны нийт зардлын гүйцэтгэлийг ангилал бүрээр авч үзэхэд зардлын хэтрэлт үүсээгүй байна.

Аймаг, сумын сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэл

Хүснэгт №2

/Төгрөгөөр/

№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл	
				АСХ	СХХ
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	250.0	250.0	-	-
2	Бичиг хэргийн зардал	10,080.0	10,079.5	0.5	-
3	Шуудан, холбооны зардал	11,650.0	11,625.7	0.1	24.2
4	Унааны зардал	35,150.0	35,150.0	-	-
5	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	3,834.0	2,024.2	1,809.8	-
6	МТБ, даамлын сургалтын зардал	8,490.0	6,270.0	2,220.0	-
7	МТБ-ийн мэдээ дамжуулах холбоо, унааны зардал	2,000.0	1,440.0	560.0	-
8	Санал авах байр, Төрийн далбаа бэлтгэх зардал	18,240.0	18,094.8	-	145.2
9	Сурталчилгааны зардал	5,000.0	5,003.0	-	(3.0)
10	Саналын хуудас, төхөөрөмж авах, буцаан хүргэх зардал	16,394.0	16,219.0	175.0	-
11	Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх	2,565.0	2,495.0	70.0	-
12	Томилолтын зардал	4,702.0	3,103.8	1,598.2	-
13	Мэдээ дамжуулах унааны зардал	1,925.0	1,540.0	-	385.0
14	Сонгуулийн хорооны гишүүний урамшуулал, хоолны зардал	252,440.0	252,440.0	-	-
15	Мэдээллийн технологийн багийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	36,810.0	36,810.0	-	-
16	Болзошгүй зардал	10,000.0	9,001.8	728.0	270.2
НИЙТ ДҮН		419,530.0	411,546.7	7,161.7	821.6

Айраг, Алтанширээ, Мандах, Сайншанд, Хатанбулаг сумын сонгуулийн хороо хуваарилсан зардлаас хэмнэгдсэн 821.6 мянган төгрөгийн зардлыг АСХ-ны дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

Харин АСХ нь 9 төрлийн зардлаас нийт 7,161.7 мянган төгрөгийн зардлыг хэмнэж СЕХ-ны дансанд нийт 7,983.3 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

СЕХ-оос зардлыг эдийн засгийн ангиллын дагуу хэмнэлттэй байхаар зарцуулах чиглэлийг тухай бүр өгсөн ба АСХ тус зөвлөмж аргачлалыг баримтлан хэрэгжүүлэн ажиллажээ.

СЕХ-оос дээрх журамд заасны дагуу АСХ-нд төсвийг зүйл анги хооронд нь шилжүүлэхгүй байх, зардлыг өөр зориулалтаар хэрэглэхгүй байх гэсэн чиглэл өгсөн хэдий ч зарим ССХ нь дээд байгууллагын зөвшөөрөлгүйгээр 3,016.4 мянган төгрөгийн зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна. Үүнд:

- ✓ Иххэт, Өргөн сумын сонгуулийн хороо санал авах байр бэлтгэх зардлаас хэмнэгдсэн 325.0 мянган төгрөгийг эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх зардалд зарцуулсан байна.
- ✓ Дэлгэрэх, Мандах, Сайншанд, Хөвсгөл, Улаанбадрах сумын сонгуулийн хороо эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх зардлаас унааны зардалд 515.4 мянган төгрөг, болзошгүй зардалд 30.0 мянган төгрөг, санал авах байр бэлтгэх, тохижуулах зардалд 267.3 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 7.4 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.
- ✓ Дэлгэрэх, Сайхандулаан, Улаанбадрах, Хөвсгөл, Эрдэнэ сумын сонгуулийн хороо сурталчилгааны зардлаас 214.2 мянган төгрөг, шуудан холбооны зардалд 65.0 мянган төгрөг, унааны зардалд 857.1 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.
- ✓ Хөвсгөл сумын сонгуулийн хороо болзошгүй зардлаас бичиг хэргийн зардалд 200.0 мянган төгрөгийг зарцуулсан.
- ✓ Иххэт, Өргөн сумын сонгуулийн хороо дүн мэдээ дамжуулах зардлаас эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх зардалд 275.0 мянган төгрөгийг зарцуулжээ.

Дээрх зөрчлийн ихэнх нь эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх зардлаас шатахуун авсан мөн бусад зардлаас энэ зардалд зориулан түлш авсан байгаа нь СЕХ-оос гаргасан заавар аргачлалд эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх зардлыг зөвхөн мотор түрээслэхэд зарцуулахаар тусгасантай холбоотой байна.

АСХ-ны 2021 оны 20 тоот албан бичгээр ССХ-нд зардал хооронд гүйлгэн зарцуулах шаардлага байгаа бол холбогдох саналаа 2021 оны 06 сарын 08-ны дотор ирүүлэх тухай мэдэгдсэн байна. Гэвч дээрх сумд хүсэлтээ ирүүлээгүй байгаа нь зөрчил үүсэх шалтгаан болжээ.

БҮЛЭГ 2. АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРОО НЬ СУМДЫН СОНГУУЛИЙН ХОРООНЫ ЗАРДЛЫН ЗАРЦУУЛАЛТАД ХЯНАЛТ БҮРЭН ТАВЬЖ ЧАДААГҮЙ БАЙНА.

2.1 Аймгийн сонгуулийн хороо нь зардлын тайланг журмын дагуу гаргасан ч зарим сумдын сонгуулийн хорооны тайланд гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 захирамжаар батлагдсан "Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам" -ын 4.1-т "Сонгуулийн зардлын дансны орлого, зарлагын гүйлгээнд холбогдох анхан шатны баримтуудыг зохих ёсоор бүрдүүлэн хадгалж бүртгэлийг НББ-ийн тухай хуульд заасны дагуу хөтөлнө" гэж заасан байна.

ССХ нь сонгуулийн зардлын тайлан, мэдээг АСХ-нд журамд заасан хугацаанд хүлээлгэн өгч АСХ журмын дагуу акт үйлдэж, зөрчилтэй тайлан анхан шатны баримтад тайлбар гаргуулан авсан байна.

Аудитаар зарим сумдын сонгуулийн хорооны нягтлан бодогч нар анхан шатны баримтыг дутуу бүрдүүлж, архивын нэгжийг буруу үдсэн зэрэг зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- ✓ Айраг, Өргөн ССХ бараа материалын орлого зарлагын баримт, шаардах хуудас зэргийг харилцахын баримттай нийлүүлэн архивласан.
- ✓ Замын-Үүд, Өргөн сумд зарим гүйлгээнд е-баримтгүй гүйлгээ хийсэн.
- ✓ Замын-Үүд сумын шатахуун зарцуулалтын тайлан жолоочийн замын хуудсанд дагалдах хуудас бөглөөгүй.

ССХ-д нь зардал хооронд зөвшөөрөлгүй зарцуулсан зардлыг бодит гүйцэтгэлээр тайлагнаагүй байна. Тухайлбал:

- ✓ Дэлгэрэх, Улаанбадрах, Мандах, Хатанбулаг, Хөвсгөл, сумын ССХ нь унааны зардалд зарцуулсан зардлыг санал авах байр бэлтгэх, тохижуулах зардал, сурталчилгааны зардалд тайлагнасан.
- ✓ Дэлгэрэх, Сайхандулаан ССХ нь бичиг хэрэг, шуудан холбооны зардлыг сурталчилгааны зардлаар тайлагнасан.
- ✓ Иххэт, Өргөн ССХ нь эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх зардлыг санал авах байр бэлтгэх, тохижуулах зардал болон дүн мэдээ дамжуулах унааны зардалд тайлагнасан.
- ✓ Хөвсгөл ССХ нь бичиг хэргийн зардлыг болзошгүй зардалд тайлагнасан.

Энэ нь АСХ-оос өгсөн заавар, аргачлалыг мөрдөж ажиллаагүйгээс шалтгаалсан байна.

2.2 Аймгийн сонгуулийн хороо нь сумын сонгуулийн хорооны зардлын зарцуулалтад тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

2021 оны А/17 "Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих" журмын 3.10-т "... аймгийн сонгуулийн хороо нь сумын сонгуулийн хорооны зарцуулалтад хяналт тавина" гэж заасан.

Аймгийн сонгуулийн хороо нь сумын сонгуулийн хороодод хөрөнгийн зарцуулалтыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулахгүй байх, холбогдох тайлан мэдээ, санхүүгийн анхан шатны баримтыг НББ-ийн тухай хуулийн дагуу бүрдүүлэн ажиллах зэрэг заавар зөвлөгөөг тухай бүр өгч ажиллажээ.

Мөн журмын 4.6-д "Аймгийн сонгуулийн хорооны нягтлан бодогч сумын сонгуулийн хорооноос ирүүлсэн санхүүгийн анхан шатны баримтыг шалган, акт үйлдэн хүлээн авна..." гэж заажээ.

Үүний дагуу аймгийн сонгуулийн хорооны нягтлан бодогч нь 14 сумын сонгуулийн хорооны зардлын тайланг нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт болон дансны хуулгаар тулган шалгаж, акт үйлдэн хүлээн авсан байна.

ССХ-ны зардлын тайланг хүлээн авахад хяналт хийж Айраг, Замын-Үүд, Алтанширээ, Даланжаргалан ССХ нь заавар журмын дагуу зардлыг зарцуулж тайлагнасан.

Харин Иххэт, Дэлгэрэх, Сайншанд, Өргөн, Сайхандулаан ССХ нь зардлыг ангиллын дагуу зарцуулаагүй, хайхрамжгүй хандсан байсныг илрүүлсэн байна.

Сонгуулийн зардал нь төрийн сангийн гүйлгээний бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний бусад зардал /210801/-ын дансаар гүйлгээ хийгддэг тул зардлыг ангиллын дагуу зарцуулж байгаа эсэхэд АСХ нь өдөр тутмын хяналт тавих боломжгүй байсан тухай тайлбар ирүүлсэн байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. СЕХ-оос АСХ-нд 16 нэр төрлийн зардалд 419.5 сая төгрөгийн санхүүжилт хуваарилсан байна
2. АСХ нь ССХ-нд 333.1 сая төгрөгийг СЕХ-ны заавар, аргачлалын дагуу хуваарилсан байна.
3. АСХ нь сонгуулийн зардлыг зориулалтын дагуу зарцуулсан боловч зарим сумдын сонгуулийн хороо зардлыг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.
4. АСХ нь нийт 411.5 сая төгрөгийг зарцуулж 8.,0 сая төгрөгийг СЕХ-ны дансанд буцаан төвлөрүүлсэн байна.
5. АСХ нь сонгуулийн зардлын тайлангийн анхан шатны баримт бүртгэлийг журмын дагуу хөтөлж тайлагнасан байна. Харин зарим сумдын сонгуулийн хороо нь зардлыг бодит гүйцэтгэлээр тайлагнаагүй байна.
6. Сонгуулийн зардал нь төрийн сангийн гүйлгээний бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний бусад зардал /210801/-ын дансаар гүйлгээ хийгддэг тул тухайн зардлыг СЕХ даргын³ журамд заасан ангиллын дагуу зарцуулж байгаа эсэхэд хяналт тавих боломжгүй байна.

³ Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих" журмын 3.10-т "Сонгуулийн хороод нь хуваарилсан зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэхгүй бөгөөд шаардлагатай бол дээд шатны сонгуулийн байгууллагад албан ёсоор хүсэлт тавьж шийдвэрлүүлнэ"

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ДОРНОГОВЬ АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРОО

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг
Утас: (705) 2-30-36, факс: (976) 70523036
И-мэйл: dga.skx2020@gmail.com

2021.07.09 № 24

танай _____-ны № _____-т

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Т.ГАН-ӨЛЗИЙ ТАНАА

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны
ээлжит сонгуулийг зохион байгуулах аймаг, сумдын
сонгуулийн хороодод сонгуулийн ерөнхий хорооноос
хуваарилсан төсвийн зардлын тайланд танай
байгууллагаас хийсэн аудитын тайлантай танилцлаа.

Тайланд өгөх санал байхгүй бөгөөд аудитаар
өгсөн зөвлөмж чиглэлийг цаашид хэрэгжүүлж
ажиллахаа илэрхийлж байна.

ДАРГА

Н.ХОНГОРЗУЛ



АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН БАГИЙН ГИШҮҮД :

Аудитор:

Б.Ариунбаатар

Аудитор:

Д.Дэмбэрэлсүрэн

ХЯНАСАН:

Аудитын менежер:

У.Оюунтүлхүүр

Дарга, тэргүүлэх аудиторовын
үүргийг түр орлон гүйцэтгэгч:

Т.Ган-Өлзий

**АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАМТРАН ОРОЛЦСОНД
ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛБЕ.**



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ**

2021 оны 08 сарын 02 өдөр

Дугаар А/2021

Дорноговь аймаг, Сайншанд сум

**Санхүүгийн аудитын тайлан
баталгаажуулах тухай**

Монгол Улсын Төрийн Аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дүгээр зүйлийн 8.2, 20 дугаар зүйлийн 20.1, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2018 оны А/207 дугаар “Эрх, үүрэг шилжүүлэх тухай” тушаалын 5 дугаар хавсралтын 1.3, 2.4, 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9, 2021 оны А/28 дугаар тушаал “Төрийн аудитын байгууллагын 2021 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “МУ-ын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулах зардлын гүйцэтгэл” сэдэвт санхүүгийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн сонгуулийн хорооны дарга нарт хүргүүлсүгэй.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Т.ГАН-ӨЛЗИЙ

